



Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: МУБИС, Боловсрол судлалын сургууль

Хөтөлбөрийн нэр: Багш, тусгай хэрэгцээт боловсрол

Индекс: D011406

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Одончимэг

Гишүүд: О.Болорсайхан

..... Б.Гэрэлтуяа

Он сар өдөр: 2020-05-29

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	МУБИС, Боловсрол судлалын сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Багш, тусгай хэрэгцээт боловсрол	
Индекс	D011406	
Шинжээчид	Ахлагч: 1. Б.Одончимэг-Шихихутуг их сургуулийн чанар, баталгаажилтын албаны дарга, Гишүүд: 2. О.Болорсайхан-АШУҮИС-ийн Чанарын баталгаажилтын албаны дарга 3. Б.Гэрэлтуяа- БСШУСЯ-ны Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын агуулга, хөтөлбөр, хэрэглэгдэхүүний асуудал хариуцсан мэргэжилтэн	
БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн	Б.Оюунчимэг	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	05/05	Шинжээчийн баг томилогдсон
	05/07	Шинжээчид гэрээ байгуулсан
	05/07	ӨҮТ хүлээн авсан.
	05/14	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	05/21-22	Сургууль дээр очиж шинжээчид ажилласан.
	05/29	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах асуудал бодлогын түвшинд чухлаар тавигдах болсон, тусгай боловсролын багшийг гадаадад бэлтгэж ирсэн уламжлал 20 гаруй жил завсардсан, боловсон хүчин дутагдсан зэрэгтэй холбоотойгоор БТХБ хөтөлбөрийг төрийн бодлогоор дэмжин, Монгол улсын дээд боловсрол, багш боловсролын салбарт анх удаа үндэсний мэргэжлийн хүний нөөц бэлтгэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, 2 удаа төгсөлт хийсэн шинэ залуу хөтөлбөр юм.

МУБИС нь БСШУСЯ-ны дэмжлэгтэйгээр хөгжлийнхөө тодорхой үе шат бүрт тэгш хамруулан сургагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багшийг бэлтгэхэд анхаарч хөтөлбөрт агуулгын шинэчлэл хийх, судлах цагийг нэмэгдүүлэх, шинэ хөтөлбөр, ном сурах бичиг, гарын авлага, боловсруулах, мэргэжил дээшлүүлэх, бусад их дээд сургуулийн (Ховд, Архангай, Дорнод) багш бэлтгэх хөтөлбөрт тусгай боловсролын чиглэлээр зөвлөн туслах дэмжлэг үзүүлэх, анги шинээр нээх (1993-1997 онд Багшийн сургуульд согог зүйч багш, арга зүйч мэргэжилтэн) зэрэг чиглэлээр ажиллаж өөрийн гэсэн туршлага, сургамжийг

хуримтлуулж ирсэн нь 2015 оноос Багш, тусгай хэрэгцээт боловсрол хөтөлбөр хэрэгжих нөхцөл болсон.

МУБИС-д 2013 оноос эхэлсэн багш боловсролын шинэчлэлийн хүрээнд “Тусгай хэрэгцээт боловсролын багш” бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж улмаар БШУ-ны сайдын 2013 оны 10 дугаар сарын 03 өдрийн 1а/5906 тоот тушаалаар баталж 2013-2014 оны хичээлийн жилийн 10 дугаар сараас 1 жилийн хөрвөх сургалтын үйл ажиллагааг 46 оюутан, 4 үндсэн, 3 гэрээт багштайгаар эхлүүлсэн.

БСШУ-ны сайдын 2013 оны 10 дугаар сарын 03 өдрийн 1а/5906 тоот зөвшөөрөл, МУБИС-ийн дэмжлэгтэйгээр 2014-2015 оны хичээлийн жилд дээрх 1 жилийн хөрвөх сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэн боловсруулж улмаар 2015-2016 оны хичээлийн жилд тусгай хэрэгцээт боловсролын багшийн 3,5 жилийн сургалтын үйл ажиллагааг 13 оюутантайгаар эхлүүлсэн. Тус хөтөлбөрөөр, 2019 оноос хойш 2 удаа нийт 29 оюутан төгсөж, эхний жилд 66,6 хувь, 2 дахь удаа, одоогийн Корона вирусын үеийн нөхцөл байдлаар 50 хувь ажлын байртай болсон байна. 2019-2020 оны хичээлийн жилийн сүүлийн хагасын байдлаар 1-3 дугаар курст нийт 56 оюутан сурч байна.

Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх хэрэгцээг тодорхойлохдоо НҮБ-ын “Хүүхдийн эрхийн конвенци”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци”, “Тогтвортой хөгжлийн зорилго-4” болон Монгол Улсын засгийн газрын хөтөлбөр, тогтоол, тушаал зэрэг бодлогын баримт бичгүүдэд тулгуурласан байна.

Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хүүхдийн сангийн тайлан, БСШУСЯ-ны судалгаанд тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших эрхийн хангалт; тусгай хэрэгцээт боловсролын өнөөгийн байдал; багшийн нөөцийн судалгаануудад дүгнэлт хийсэн.

ТХБ-ын тэнхим 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн 11 удаагийн хэрэгцээ тодруулах судалгааг гүйцэтгэн БНСУ, АНУ, ОХУ-ын их дээд сургуулийн хэрэгжүүлж буй ижил төстэй хөтөлбөрүүдийн агуулгыг харьцуулан судалж, хөтөлбөрийн баримт бичгийг боловсруулжээ.

Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага болон хэрэгжүүлэх үйл явцыг Монгол орны нөхцөлд тохируулан шат дараатай хийсэн гэж үзэж байгаа бөгөөд үүнийг хөтөлбөр боловсруулсан 5 хүнтэй багийн бүрэлдэхүүний мэргэжлийн бэлтгэл, тусгай боловсролын салбар, түүнийг шинэчлэх чиглэлээр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласан туршлага, боловсролын түвшин, мэргэжил дээшлүүлсэн, эрдмийн зэрэг цолны байдлаас

харагдаж байна. (4 багш хуучнаар ЗХУ-д тусгай согог зүйч мэргэжлээр төгссөн, тусгай боловсролыг шинэчлэх төслийн үйл ажиллагаанд оролцсон, сонсгол, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд 7-18 жил ажилласан, доктор Ph.D цолтой, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн судлаачид, шинэ хөтөлбөр хэрэгжүүлэхэд биечлэн оролцсон туршлагатай, англи хэлний, чадвар сайн, хөтөлбөрийн шинжээч, эмч, нийгмийн ажилтан мэргэжилтэй залуу боловсон хүчин)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Хэрэгцээ тодорхойлох судалгаанд хот хөдөөгийн ЕБС-ийн багш, бусад хөтөлбөрөөр суралцагч оюутан, тусгай сургуулийн удирдлагууд, төгсөгчдийг хамруулан үе шаттай зохион байгуулжээ.

Хөтөлбөрийг хөгжүүлэх явцдаа зэрэгцүүлэн 2014 оноос багш мэргэжлийн суурийн “Тусгай хэрэгцээт боловсролын үндэс “ 2кр сонгон судлах хичээлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн, жил бүр сонгон судлах оюутны тоо нэмэгдсэн дүнтэй байна.

Монгол улсад анх удаа шинээр эхэлж хэрэгжсэн, дотоодын туршлага, сургамж суралцах боломж бага, боловсон хүчний нөөц хязгаарлагдмал хэдий ч төрийн бодлого, МУБИС-ийн дэмжлэгтэйгээр богино хугацаанд амжилттай хэрэгжжээ.

Анхаарах асуудал:

- Бенчмаркинг судалгаанд ижил, төстэй хөтөлбөрүүдийн төгсөгчийн загвар, үзэл баримтлалын харьцуулалтыг тусгаагүй байна.

Зөвлөмж:

- “Special Needs Teacher Education” чиглэлийн хөтөлбөрүүдийг түүвэрлэн судалж, тэгш хамруулах боловсролын багшаас ялгаатай талыг тодруулах
- Хөтөлбөрийн цаашдын хөгжлийг өөрийн болон гадаад орны тэгш хамруулах боловсролын одоогийн болон ирээдүйн чиг хандлагатай холбон тодруулах

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр байх үзэл баримтлалын дагуу МУБИС-ийн шинэ зууны багшийн загвар, багш боловсролын зорилгыг хангахад чиглүүлэн хөтөлбөрийн суралцахуйн /PLO/ болон судлагдахууны /CLO/ үр дүнг тодорхойлжээ.

Хөтөлбөрийн зорилгыг цогц чадамжийн ай бүрээр хувь хүн, багш боловсрол, академик чиглэлээр суралцахуйн 49, судлагдахууны 795 үр дүнгээр задлан төлөвлөсөн байна.

ТХББ хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн 2014-2015 оны хичээлийн жилээс хойш нийт 4 удаа тэнхим, хөтөлбөрийн дэд болон ерөнхий хорооны хуралдаанаар агуулга, арга зүйн талаар хэлэлцүүлж, хөтөлбөрт 1 удаа өөрчлөлт оруулан сургалтын төлөвлөгөөг шинэчилсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үр дүнд суурилсан сургалтын үзэл баримтлал, цогц чадамжид чиглэсэн зорилго зорилтыг уялдуулан төлөвлөсөн байна.

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөрийн төгсөгчийн загвар, ерөнхий шинжийг багш, судлаач, зөвлөгч, холбон зуучлагч, менежер, хамтран ажиллагч гэсэн байдлаар тодорхойлсон ч оновчтой загварчлах, хөтөлбөр сурталчлах тал дээр анхаарч сайжруулах
- Суралцахуйн болон судлагдахууны үр дүнгүүд хэт олон байгаа нь үр дүнд хүрсэн эсэхэд шинжилгээ үнэлгээ хийх; тухайн үр дүнд хүрэх бодит боломжийг төлөвлөхөд төвөгтэй байх магадлалтай.

Зөвлөмж:

- Тухайн хөтөлбөрийн төгсөгчийн загварыг оновчилж, хөтөлбөрийн үр дүнг хэмжигдэхүйц байх SMART зарчмыг хангах шаардлагатай.
- Тухайн хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн холбоог байгуулж хөтөлбөрийн хөгжилд оролцуулах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын төлөвлөлтийн баримт бичиг нь БСШУЯ-ны А/174 дүгээр тушаал, МУБИС-ийн Сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамжийн дагуу боловсруулагдаж, 2015 оны хавар албажсан байна.

Хөтөлбөрт оруулсан нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэг, хөтөлбөрийн ерөнхий хорооны шийдвэрийг хавсаргаж, тухайн өөрчлөлтийг тусгасан сургалтын төлөвлөгөөг баталгаажуулан мөрдөж байна.

Хөтөлбөрийн баримт бичигт нийт 59 судлагдахууны танилцуулга багтсан бөгөөд судлагдахууны эзлэх хувь “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-д нийцсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Өөрийн үнэлгээний тайланд суралцагчийн ачааллыг хичээлийн цагаар гаргасан ч сургалтын төлөвлөгөөнөөс тодорхой харагдахгүй байна.

Зөвлөмж:

- Суралцагчийн ачааллыг улирал тутам тэнцвэртэй тогтоож, дасан зохицох, ачаалал даах, бие даан суралцах боломж олгосон байдлаар төлөвлөх; суралцахуйн болон судлагдахууны үр дүнг үнэлэх арга зүйг оновчилж, хөтөлбөрийн баримт бичигт тусгах шаардлагатай.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Уг хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл шалгуур үзүүлэлтийн хүрээнд хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц, удирдлагын мэдээллийн системд хичээл, багш сонгох боломжтой, сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ, дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ, хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/, суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа зэргийг сургуулийг үйл ажиллагаа, илрэл нотолгоо зэрэгт тусгагдсан байна.

Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд 2018 онд үнэлгээ хийгдэж шинэчлэлт хийгдэж сэтгэл судлал, боловсрол судлалын хичээл, дадлагын цаг хэт их, нийгмийн ухаан, байгалийн ухааны мэргэжлийн багш бэлтгэхэд мэргэжлийн хичээлийн цаг хомсдолтой гэж үзсэн тул “Хүний хөгжлийн сэтгэл судлал” 2кр, Судлах дадлага 1кр хичээлд өөрчлөлт оруулж улмаар сургалтын төлөвлөгөөнд мэргэжлийн хичээлийн зохицуулалт, хичээлийн нэршил, цагт өөрчлөлт оруулж хөтөлбөрийн тасралтгүй хөгжих үйл явцыг хангаж байна.

БТХБ-ийн ангийн оюутнуудын дадлагыг УБ хотын хараа, сонсгол, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай 6 сургуультай дадлагын хичээлийн хамтран ажиллах гэрээ, багшлах дадлагын гүйцэтгэлийг 2015-2020 оноор цагийн ачааллыг хүснэгтээр гарган ӨҮТ, илрэл нотолгоо зэрэгт тусгасан байна.

МУБИС-ийн хөтөлбөрийн албанаас оюутанд зориулсан дадлагын удирдамж, журмыг тусгасан дараах 2 багц дэвтрийг боловсруулан хэвлүүлсэн. Ж нь: танилцах дадлага, судлах дадлага-1, судлах дадлага-2, дагалдан суралцах дадлага, туршин заах дадлага, багшлах дадлагын агуулга гэж боловсруулан хэрэглэж ТХББ-ийн ангийн оюутнуудтай дадлагын дараа ярилцлага хийж үзэхэд дээрх дадлагын дэвтрийн даалгавар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тусгай сургуулийн нөхцөлтэй таарахгүй байгаа тул ТХББ-ийн ангийн оюутнуудад зориулсан дадлагын дэвтрийг

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд зохиох ажлын хэлбэр, төлөвлөгөө
- Тусгай сургуулийн нөхцөлд хичээлд тавигдах шаардлага,
- Хичээлээс гадуур зохион байгуулах ажил
- Хичээлд өөрийн үнэлгээ хийхэд анхаарах зүйлс гэх мэт агуулгыг тусгаж өөрчилсөн байна.

Баримт нотолгоонд 22 материалын жагсаалт гаргасан байлаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц,

- Удирдлагын мэдээллийн системд хичээл, багш сонгох боломжтой;

Зөвлөмж:

- Тусгай сурганы дидактик арга зүйг түлхүү оруулах, тухайлбал, тусгай сурганы математик заах арга зүй, монгол хэл заах арга зүй, гар хөдөлмөр заах арга зүй зэргийг бие даасан судлагдахууны түвшинд хэрэгжүүлэх
- Уг хөтөлбөрт шинээр боловсруулж буй мэргэшлийн үндэсний хүрээ, үндэсний хэвшинжийг тусган хөгжүүлэх
- Хөтөлбөрт Е.АТ 412 код бүхий Урлаг, гоо зүйн засал хичээл тусгагдсан ч цаашид урлаг, урлагийн чиглэлийг агуулгыг түлхүү тусгах тал дээр илүү анхаарах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

Хүүхэд бүрийн хувийн ялгаатай байдал, хэрэгцээ, сонирхол, хөгжилд нь тохирсон сургалтын арга зүйг хэрэглэхээр төлөвлөж байгаа нь сайшаалтай байна.

Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг үнэлэх тогтолцоог сургалтын журам, оюутны журам зэрэг баримт бичигт тусган хэрэгжүүлдэг бна.

Багш, тусгай хэрэгцээт боловсрол хөтөлбөрт орсон тусгай сурган хүмүүжүүлэх зүйн сургалтын өвөрмөц заах арга зүй, хэрэглэгдэхүүн шаарддаг тул сургалт зохион байгуулахдаа сургалтын онцлог байдал, хэрэгцээ шаардлага арга зүйн тайлбарыг товч тоймлон тухайн хичээлийн агуулга, аргазүй, үнэлгээний талаар тайлбарладаг байна.

Мөн хичээлийн агуулга, үр дүнг оюутанд хүргэхийн тулд суралцагч төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, идэвхтэй арга хэлбэрийг зохистойгоор хослуулах, дэвшилтэт технологи ашиглах, хамтдаа багаар, ганцаарчлан, хосоор зэрэг хэлбэрээр ажиллаж, суралцах боломж олгосон цогц арга технологийг хэрэгжүүлэх сургалтын арга зүйг хэрэглэж байгаа талаар ӨҮТ, сургуулийн үйл ажиллагаа, илрэл нотолгоо зэрэгт тусгагдсан байна.

МУБИС-ийн сургалт, хөтөлбөрийн албанаас нийт багш нарыг хамтран суралцахуй, хичээлийг идэвхтэй сургалтын аргаар зохион байгуулах талаар сургасан, багш нар ч энэ чигийг барьж ажиллахаас гадна өөрсдөө сургалт зохион байгуулж хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгч ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хүүхэд бүрийн хувийн ялгаатай байдал, хэрэгцээ, сонирхол, хөгжилд нь тохирсон сургалтын арга зүйгээр сургалтыг зохион байгуулж байна.

Зөвлөмж:

- БТХБ хөтөлбөрийн гэрээт багш нарыг идэвхтэй сургалтын аргаар хичээл зохион байгуулах талаар сургалтад хамруулах. Цахим сургалтыг идэвхитэй сургалтын арга хэлбэрээр түлхүү зохион байгуулах

Баримт нотолгоонд 29 материалын жагсаалт гаргасан байлаа.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

МУБИС-ийн Үнэлгээний даалгаврын сан бүрдүүлэх удирдамж (2015), хичээлийн үнэлгээний удирдамж, шалгуур (2017), МУБИС-ийн Багшийн вебд байрлуулсан онлайн тестийн сан үүсгэх видео зааврын дагуу бүх суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүнгийн гүйцэтгэлийг үнэлдэг. Уг журмаар явцын, ахицын, эцсийн холбоотой харилцааг зохицуулж байна.

Өөрийн үнэлгээний тайлангаар, хөтөлбөрийн явцад суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх боломжтой үнэлгээний аргуудын олон төрөл хэлбэрийг хэрэглэдэг гэж дурджээ. ӨҮТ-д төгсөлтийн шалгалтын хэлбэр, агуулга хүснэгтэнд 1,2 хувилбараар төгсөлтийн шалгалт өгөх боломжтой сонголттой уян хатан байдлаар төлөвлөсөн байна.

Дипломын ажил бичиж судалгааны арга зүйд суралцуулж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж, хичээл нэг бүрт дүн шинжилгээ хийж явцын болон төгсөлтийн шалгалтын журмын дагуу үнэлгээ дүгнэлт хийгдэж байна.

Тэнхимийн багш нар 2019 оны 1-р сарын 10-11 нд МУБИС-аас зохион байгуулсан “Хичээлийн үнэлгээний арга зүй” зэрэг сургалтад сууж үнэлгээний даалгаврын санг бүрдүүлэх, түүний чанарыг тогтмол тасралтгүй сайжруулж байна.

МУБИС-ийн захирлын 2018 оны 11-р сарын 22-ны А/287 тоот тушаалын дагуу багш бүр өөрийн заадаг хичээлийн үнэлгээний даалгаврыг тухайн хичээлээр оюутанд эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлага (CLO) болон 2018 оны 12-р сарын 18-нд батлагдсан хөтөлбөрийн PLO-той уялдуулан шинэчлэн боловсруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Үнэлгээний аргын талаар ӨҮТ-д дэлгэрэнгүй тусгах

Зөвлөмж:

- Шалгалтыг олон үнэлгээний аргаар авах шалгалтын санг бүрдүүлэх
- Багш нар бие биенээсээ суралцах боломж олгох, хэлэлцэх

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан байна. Тухайлбал,

- МУБИС-ийн дотоод журам (2019)
- МУБИС-ийн оюутны журам (2018)
- Оюутны байрын дотоод журам
- МУБИС-ийн хөгжлийн бодлого /2014-2024/ -ын “Сургалтын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх” зорилт
- Сургалтын анги танхимын хэмжээ хангалтай. Эзэмшил газар нь барилгын нийт 3090м.кв-аас 3000 м.кв-ыг эзэлдэг. Нэг оюутанд 2.8 м.кв талбай ноогддог.
- Анги танхимын болон техник хэрэгслийн хангалт сайн. 18а танхим нь 18 ширээтэй 36 сандалтай,, 37а тоот танхимыг ТХБТ-д 2017 онд хүлээлгэн өгсөн. 2 танхимд мэргэжлийн хичээлүүд ордог.
- 1500 оюутныг хүлээн авах 4 дотуур байртай.
- Тэнхимийн багш нарын ажлын байрны ажиллах 2 өрөөтэй. Ажиллах нөхцөл бололцоог хангасан техник хэрэгсэлтэй.
- 2014-2018 оны хугацаанд сургалтад МУБИС-ийн ULMS (University Learning Management System) системийг хэрэглэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/туршлага/

- Тусгай хэрэгцээ шаардлагатай оюутанд зориулсан хаалганы пандус, бусад зүйлсийг хийсэн. Тусгай хэрэгцээт боловсролын багшийн эзэмших шаардлагатай тусгай хэрэглэгдэхүүний лабораторитой болж байгаа.

Зөвлөмж:

- Хөдөлмөрийн гэрээ болон цагийн багшийн гэрээнд багш өөрийгөө хөгжүүлэн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх заалтуудыг түлхүү оруулах.
- Багшийг сурч боловсроход үзүүлдэг дэмжлэг, хөнгөлөлтийн системтэй болох.

3.2 Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

МУБИС-ийн Сургалтын журмын 3.31-т “МУБИС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авах зардлыг МУБИС-ийн төсөвт тусгаж хэрэгжүүлнэ” заалтын хүрээнд

Тусгай хэрэгцээт боловсролын багшийн зайлшгүй мэдэж, сургалтад ашиглах доорх хэрэглэгдэхүүнтэй.

- Харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан компьютер 2 ш
- Томруулагч дэлгэц 2 ш
- Брайль принтер 1
- Томруулагч шил 0
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дуу хөрвүүлэгч 2
- Энгийн тэргэнцэр 1
- Автомат тэргэнцэр 1
- Таяг 1 /тулгуур эрхтний бэрхшээл/
- Цагаан таяг 1 /харааны бэрхшээл/
- Алхуулагч 1
- 3D принтер 1 /харааны бэрхшээл/ гэх мэт.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/туршлага/

- Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд зориулсан тохирох хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж оюутнуудад ашиглах арга барил эзэмшүүлж байна.

3.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол чанартай хангадаг байна.

Илрэх нотолгоо:

Суралцагчдад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай хэрэглэгдэхүүн, номын сангийн үйлчилгээ, цахим орчин, суралцахуйн орчинг хангалттай бүрдүүлсэн байна. Тухайлбал,

- Боловсрол судлалын чиглэлийн ном сурах бичиг
- Электрон катологи
- Уншлагын заал
- Брайль сурах бичгийн хэсэгтэй
- Epub номын фондтой
- МУБИС-ийн номын сан нь 195000 ном, сурах бичигтэй /ТХБ-ын чиглэлийн 1500 ш ном, сурах бичигтэй/
- Нийт 35 лаборатори /тэнхим 1 лабораторитай/
- Сургалтын үйл ажиллагаанд ажиглалт хийх танхимтай /лицей сургуульд түшиглэсэн/

Нэр хүндтэй 10 орчим эрдэм шинжилгээ, судалгааны сангийн эрхийг авч нийт 8000 орчим цахим сэтгүүл, ном, ЭШ-ний илтгэл өгүүлэл, танилцуулгын эрхийг авч судлаачдад танилцуулах ажлыг хийж байна. Үүнд:

- МУБИС-ийн цахим номын сан <http://catalog.mnue.mn>
- SPRINGER <http://link.springer.com>
- Annual Reviews <http://www.annualreviews.org>
- Онлайн мэдээллийн сан <http://elibrary.imf.org>
- Геологийн нийгэмлэг <http://lyellcollection.org>

- Вангийн нийгэмлэг <http://www.royalsocietypublishing.org/journals>
- University of Chicago Press <http://www.journals.uchicago.edu>
- SPIE <http://spiedigitallibrary.org>
- Цахим номын сан <http://www.jstor.org>

МУБИС-ийн номын сан SPRINGER Nature-тай гэрээ хийн тэдний хэвлэсэн 1900 гаруй сэтгүүл болон 1200 е-датабаз руу нэвтрэх эрхийг МУБИС-ийн оюутан багш нарт олгоод байна. Мөн дараах олон улсын е-датабаазд нэвтрэх эрхтэй болсон.

- <https://www.annualreviews.org>
- <https://www.lyellcollection.org>
- <https://www.liverpooluniversitypress.co.uk>
- <https://www.journals.uchicago.edu>

ТББ-ын төлөөлөлтэй хамтран ажиллаж, сүүлийн үеийн онол арга зүйн чиглэлийн сурах бичиг, гарын авлага, зөвлөмж боловсруулж байгаа.

2020 онд АХБ-ны “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоотой хамтран Брайль бичгийн 25 сургагч багш бэлтгэгдэх сургалтыг зохион байгуулж, Брайль бичгийн сургалтын модуль боловсруулсан.

Мөн “Харааны бэрхшээлтэй хүнд хөтөч хийх аргачлал” боловсруулсан. Түүнчлэн “Сонгоггүй боловсрол” ТББ-тай хамтран дохионы хэлний 25 сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж “Дохионы хэл” модуль сургалтын хөтөлбөр боловсруулсан. Монголын Аутизмын холбоотой хамтран, аутизмтай Монгол хүүхэд, эцэг эхтэй ажиллах дадлага хичээлийг хамтран хэрэгжүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Зөвлөмж :

- Номын сангийн фонтод тус сургуульд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй /хараа / оюутны судалж байгаа судлагдахууны сурах бичгийг брайль, дейзи хэлбэрээр нэмэгдүүлэх
- Цаашид сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, өргөжүүлэх талаар хөрөнгө оруулагч талын оролцоог улам нэмэгдүүлэх шаардлагатай.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь МУБИС-иас хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой салбарын бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулсан 16 төрлийн эрх зүйн актыг мөрдөн ажилладаг.

Төрөөс боловсрол, шинжлэх ухаан, технологи, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүний эрхийн талаар баримтлах бодлогын 12 баримт бичгүүдийн үзэл санааг хөтөлбөрт тусгасан талаар матриц шинжилгээ хийсэн байна.

Тэнхимийн хурал, хөтөлбөрийн дэд болон ерөнхий хорооны хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудал, хэлэлцүүлгийн тэмдэглэлийг он дарааллаар албажуулан архивласан байна.

Хөтөлбөрт ирсэн санал гомдлыг барагдуулах талаар санаачилгатай ажиллаж, сонсголын бэрхшээлтэй оюутнуудад дохионы хэлмэрчийн үйлчилгээг төслийн хүрээнд үзүүлж ирсэн байна. ТХБТ нь 2019-2022 он хүртэл стратеги төлөвлөгөө боловсруулан хичээлийн жил, улирал, сараар ажлаа төлөвлөн тайлагнадаг. Тэнхимийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн сургуулийн удирдлага хянан ахиц дэвшлийн үнэлгээ хийдэг.

Удирдлага, мэдээллийн ULMS1.0 системийг 2014 оноос нэвтрүүлэн багш, суралцагч, сургалт, эрдэм шинжилгээ, захиргаа, удирдлагын үйл ажиллагааг нэгдсэн тогтолцоогоор удирдаж байна. Гэвч сургалтад оролцогч, сонирхогч талууд тухайн хөтөлбөрийн талаар МУБИС-ийн болон БоСС-ийн сайтад тодорхой мэдээлэл байршаагүй ч магадлан итгэмжлэлийн явцад хөтөлбөрийн албанаас анхааран ажиллаж элсэлтийн сурталчилгаа, БТХБ хөтөлбөрийн танилцуулга хийсэн нь сайжруулах, хөгжүүлэх боломжтой.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Бие даасан удирдлага, мэдээллийн системээр сургалтын цогц үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- Их сургууль болон бүрэлдэхүүн сургуулийн сайтад хөтөлбөрийн танилцуулгыг сайжруулан байршуулах

Зөвлөмж:

- Сайт болон бусад олон нийтийн цахим талбарт хөтөлбөрийн талаар мэдээлэл байршуулах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөр хэрэгжүүлэгчид нь ОХУ, АНУ, Финлянд, Япон, Солонгос улсын их дээд сургууль, ЖАЙКА, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллага, БСШУСЯ, НХХЯ, ХБХХЕГ, СЗСҮТ, БХ, БМДИ, НТБҮТ, 29, 25, 63, 116, 55, 70 дугаар тусгай сургуулиуд, 28, 16, 35, 34, 79 дүгээр ЕБС, Баян-Өлгий аймгийн багшийн коллеж, Дорнод их сургууль, Монголын Дауны холбоо, Аутизм Монгол-Анд болон бусад ТББ –уудтай нягт хамтран ажилладаг.

Японы Хёгогийн Боловсролын их сургуульд 4 багшийг магистрын хөтөлбөрт суралцуулж, ОХУ-ын Эрхүүгийн их сургуулийн профессор Светлана Юрьевнагийн “Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт сургалтад 50 гаруй багш, тусгай сургуулийн хэл засалч багш нартай хамтран хөтөлбөрийг хөгжүүлэх зорилгоор “ Хэл

заслын үндэс” 3 кр нэмэлт сургалтын хөтөлбөр боловсруулан сургалт зохион байгуулж 26 багш тус тус хамруулжээ.

Мөн олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад идэвхтэй оролцож байна.

Тэнхимийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалт, судалгаа, зөвлөмжийг тогтмол хэрэгжүүлж байгаагаас Дохионы хэлмэрч орчуулагчдын холбоотой хамтран 2016-2018 оны хичээлийн жилд “Дохионы хэл” сонгон судлах хичээлийн хөтөлбөр хөгжүүлсэн үр дүнгүүдтэй.

Тэнхим хөрвөх хөтөлбөрөөр төгсөгчдийг зохион байгуулж буй сургалт, эрдэм шинжилгээний хуралд өргөнөөр хамруулдаг нь тайлан, уулзалт ярилцлагаар батлагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хөгжүүлэхэд төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг далайцтай хэрэгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн холбоонд тус хөтөлбөрийн төгсөгчийн төлөөлөл байхгүй, бүрэлдэхүүн сургууль, хөтөлбөрийн түвшинд төгсөгчдийн өөрийн удирдлага, санаачилгын нэгж байхгүй.

Зөвлөмж:

- Төгсөгчдөө идэвхжүүлж, өөрийн удирдах байгууллагын зохион байгуулалтад оруулахад дэмжлэг үзүүлэх шаардлагатай.
- Тэнхимийн дэргэдэх хөтөлбөрийн дэд хороонд туршлагатай мэргэжлийн багш нар, ажил олгогч, төгсөгчийн төлөөлөл оруулж өргөтгөх шаардлагатай.
- Тусгай хэрэгцээт боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах дидактик арга зүй, тусгай сэтгэл зүйн чиглэлийн мэргэжил-арга зүйн сэтгүүл эрхлэн гаргах шаардлагатай.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь төсөв санхүүгийн хувьд бие даасан байдалтай, тодорхой хэмжээний эрх мэдэлтэй байх эрх зүйн зохицуулалтыг МУБИС-ийн Санхүүгийн журамд тусгасан байна. 2018 оны байдлаар ТХБ-ын тэнхим 202,605,000 төгрөгний орлого, 95,700,000 төгрөгний зардал, 106,950,000 төгрөгний ашигтай ажилласныг тайлагнажээ.

Нийт орлогын 70 орчим хувийг хөтөлбөрийн хэрэгжүүлэлтэд зарцуулж, 30 хувийг хөгжлийн санд байршуулдаг талаар тайланд тусгасан. Мөн ТХБ-ын тэнхим 2018-2019 оны хичээлийн жилд Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр 92,778,072 төгрөгийн санхүүжилт бүхий төсөл хэрэгжүүлэн хөтөлбөрийн хөгжүүлэлтэд зарцуулсан байна.

Мөн оюутны хөгжил, өөрийн удирдлагын байгууллагын дэмждэг зардлыг тайлагнаж, нэг оюутанд ногдох дундаж зардлыг сүүлийн 5 жилээр тодорхойлсон байна. Зардлын нийт дүн оюутны тоотой шууд хамааралтай бөгөөд нэг оюутанд ноогдох дундаж зардлын задаргаа тодорхойгүй байна.

Харин оюутны суралцах үйл ажиллагааг дэмжин ЖАЙКА байгууллагын төслөөр сүүлийн 2 хичээлийн жилийн турш тэтгэлэгтэй дадлага хэрэгжүүлжээ.

Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар төдийгүй сургалтын албаны мэргэжилтэн, бусад хөтөлбөрийн багш, төгсөгчдийг хөгжүүлэх зардлыг төсөв, төсөл хөтөлбөрөөс санхүүжүүлсэн байна.

Ярилцлага, нотлох баримтаар хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн төслийн санхүүжилт, хэрэгжүүлэлт, түүний тайланд хөтөлбөрт оролцогч талууд сэтгэл хангалуун, цаашид дэмжин ажиллах хандлагатай байна.

Магадлан итгэмжлэлийн явцад Азийн хөгжлийн банкны Дээд боловсролыг дэмжих төслийн хүрээнд тухайн хөтөлбөрийн лабораторийн тоног төхөөрөмжийг хүлээн авч байсан.

Сургалтын болон оюутны байрны төлбөр шинэчлэн тогтоох тухай УЗ-ийн 2018 оны тогтоолоор тухайн хөтөлбөрийн судлагдахуунуудын 1 кредитийн үнэлгээг сургалтын хэрэглэгдэхүүнийг харгалзан нийтлэгээр 71000 төгрөг, Аутизмын хүрээний эмгэг – сонгон судлах хичээл 78,000 төгрөг, Урлаг гоо зүй засал - сонгон судлах хичээл 78,000 төгрөг, Танилцах, судлах, туршин заах дадлага, багшлах дадлага -72,000 төг тус тус тогтоосон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамрагдан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа сайн авч байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн бие даасан байдал, тодорхой хэмжээний санхүүгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Зардлыг цалин, шимтгэл, бичиг хэрэг, шуудан интернет, гадаад томилолт, гадаад зочны зардал, нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, бусад зардал гэж ангилсан боловч ТХББ хөтөлбөрийн суралцагчдын нэг бүрийн хэрэгсэл, сургалтын дидактик материалын зардал, лаборатори, тоног төхөөрөмжийн зардал, зэрэг ангилал харагдахгүй байна.
- Тухайн хөтөлбөрийн нэг оюутанд ноогдох зардлын задаргаа тодорхойгүй байна.

Зөвлөмж:

- Тухайн хөтөлбөрийн нэг оюутанд ноогдох зардал, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн зардал, судлагдахууны сургалтын хэрэглэгдэхүүний зардал зэргийг хөтөлбөрийн онцлогт нийцүүлэн төлөвлөж, төсөвлөх шаардлагатай.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Тусгай хэрэгцээт боловсролын багшийн хэрэгцээг бага, дунд боловсролын салбарын статистик судалгаа, төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд иргэдийн талаар баримтлах бодлого, төлөвлөлтөд тулгуурлан тодорхойлсон байна. Тайланд дурдсанаар нийт 2800 ажлын байрны эрэлт хэрэгцээ үүсчээ.

Хөтөлбөрөөр суралцагчдыг сэдэлжүүлэх зорилгоор хөдөө орон нутгийн захиалгат дадлага хийсэн суралцагчдад сургалтын төлбөрийн 30 хувьтай тэнцэх тэтгэлэг олгож байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, уулзалт хэлэлцүүлэг, сургалт семинар, ЭШХ зэргээр дамжуулан хөтөлбөрөө байнга сурталчилдаг талаар тайлагнасан.

Төгсөгчдийн хэрэгцээ тодорхойлох судалгаагаар 17 багш тухайн хөтөлбөрийн чиглэлээр магистрын түвшинд суралцах хүсэлтээ илэрхийлсэн байна.

Жил бүр тухайн хөтөлбөрөөр элсэгч бүрдүүлэх, мэргэжил сурталчилах ажлын төлөвлөгөө гаргаргаж, хэрэгжүүлдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан
Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн талаар сургуулийн сайтад мэдээлэл хангалтгүй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн сурталчилгаанд эрэлт үүсгэх, сонирхол татах олон хэлбэрийн арга хэрэгсэл, ялангуяа нийгмийн сүлжээ; цахим мэдээлэл; чанар, үр өгөөжийн талаар ам дамжсан мэдээлэл; оюутны холбооны үйл ажиллагаа зэргийг ашиглах шаардлагатай.

4.5. Хөтөлбөрийн нээлтэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

Тэнхим хөтөлбөрийн талаарх мэдээллийг сүүлийн жилүүдэд Монголын Үндэсний олон нийтийн телевиз, Ийгл телевиз, TV5, TV9, UBS, MNC, Монгол HD телевизүүд болон FM радио, нүүр номын хуудсаар байнга сурталчилж ирсэн.

МУБИС-ийн веб сайт, бүрэлдэхүүн сургуулийн веб сайт, Сургалтын албаны нүүр ном, оюутны нүүр ном зэрэг цахим хэрэгслүүдтэй.

Хөтөлбөр хэрэгжүүлэгчид сүүлийн 5 жилд дотоодод 39 эрдэм шинжилгээний өгүүлэл, гадаадад 12 ЭШӨ, гадаад дотоодын ЭШХ-д 12 илтгэл, 33 ном гарын авлага, 14 редакци, 5 орчуулгын бүтээл гаргаснаа тайлагнажээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан
Анхаарах асуудал:

- Их сургуулийн веб сайт нь дотоод үйл ажиллагаанд бүрэн хэрэглэгдэж байгаа боловч олон нийтэд хөтөлбөрөө сурталчлах, хөтөлбөрийн талаар элсэгч, сонирхогч талуудад өгөх тогтвортой мэдээлэл хомс.

Зөвлөмж:

- Их сургуулийн болон бүрэлдэхүүн сургуулийн веб сайтад тусгай хэрэгцээт боловсролын багш хөтөлбөрийн төгсөгчийн загвар, хүрэх үр дүн, ажлын ба, дэвшин суралцах боломжийн талаар мэдээлэл байршуулах шаардлагатай.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байх.

5.1 Суралцагч сонгон элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэх нотолгоо:

- Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, БСШУЯ-ны сайдын 2013 оны А/79 тоот тушаалын “Оюутан элсүүлэх журам”
- МУБИС-ийн элсэлтийн журамтай.
- МУБИС-д оюутан элсүүлэх талаарх дүрэм журам болоод элсэгчдэд зориулсан сурталчилгаа, мэдээллийг МУБИС-ийн <http://www.msue.edu.mn/> гэсэн вэб хуудсанд байршуулдаг. 2015-2016 оны хичээлийн жилд Тусгай хэрэгцээт боловсролын багшийн ангид 11, 2016-2017 онд 24, 2017-2018 онд 29, 2018-2019 онд 31 оюутан элсэн орсон байна.
- МУБИС-ийн сургалтын журмын 3.29-т “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бэрхшээлийн төрлөөс үл хамааран МУБИС-ийн бүх хөтөлбөрт элсэн суралцах боломж олгодог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/туршлага/

- Багш мэргэжлээр суралцах оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлтийн тогтолцоотой.

Зөвлөмж:

- Тус хөтөлбөрийн элсэлтийн бодлого, маркетингийн төлөвлөгөөг сайжруулан боловсруулах нь зүйтэй. Ажил олгогчидтой хийсэн ярилцлагын үеэр гарсан доорх саналуудыг цаашдаа элсэлтийн бодлогодоо тусгах, үүнд:

Энэ мэргэжлийн онцлогийн хувьд зөвхөн хүүхэд бус гэр бүл, орчин тойрны хүмүүсийн хувьд ч тодорхой асуудалтай байдаг. Ийм учраас эдгээр хүмүүстэй ажиллах чадвартай, сэтгэл зүйн хувьд төлөвшилтэй, хандлагатай байх хэрэгтэй. Тэгэхээр энэ мэргэжлээр элсэн суралцагчийн харилцаа, хандлага дээр анхаараасай гэж бодож байна. Оюутныг элсүүлж авахдаа анхаарах хэрэгтэй. Мэргэжилдээ сонирхолтой байх хэрэгтэй.

5.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэлзүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэх нотолгоо:

Зөвлөн туслах үйлчилгээ нь суралцагчийн хэрэгцээ, шаардлагыг хангаж, сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн байна.

- Оюутанд үйлчлэх албатай
- Анги, бүлэг бүр зөвлөх багштай
- Оюутны гарын авлагатай
- Тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Оюутны цахим ном” гарын авлагаас авах бүрэн боломжтой
- нийгмийн сүлжээг оюутанд чиглэсэн үйлчилгээнд ашиглаж байна.
- www.facebook.com/mubisexcellentstudents,
- www.facebook.com/БАГШЛАХ_ДАДЛАГА
- www.facebook.com/mubisexcellentstudents

- 2015-2016 онд оюутны хөгжлийг дэмжихэд мэргэжлийн чиглэлээр 5 удаагийн сургалт, мэдээллийн үйл ажиллагаа
- 2017-2018 онд 3 удаагийн үйл ажиллагаа
- 2018-2019 онд 6 удаагийн үйл ажиллагаа
- 2019-2020 онд 5 удаагийн үйл ажиллагаа явуулсан байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/туршлага/

- Оюутны хөгжлийн хөтөлбөр /2019-2024/ батлагдсан. Оюутанд үйлчлэх ажилтны ажлын байрны тодорхойлолтыг батлан хэрэгжүүлж байгаа.

Зөвлөмж:

- Гадаадын ижил хөтөлбөр хэрэгжүүлэгч сургуулиудтай цахим эх сурвалж солилцох гэрээ байгуулж ажиллах.

5.3 Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэх нотолгоо:

Оюутны олон нийтийн ажилд оролцсон байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласан оролцоог урамшуулах, цалинжуулах ажлыг зохион байгуулдаг.

- Засгийн газрын өндөр онооны 70%, 100% тэтгэлэг
- Буцалтгүй тусламж
- Оюутны хөгжлийн зээл
- МУБИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг
- замын зардлын тэтгэлэгт хэрхэн хамрагдах заавар зөвлөгөө
- 2018 оноос Багшлах дадлагыг тэтгэлэгтэй хийж байна /жил бүр 8-10 оюутан тэтгэлэгтэй дадлагатай хийж байна/
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутны хөгжил, санаачилгыг дэмжин ажилладаг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/туршлага/

Оюутны сайн дурын ажлыг тогтмол зохион байгуулдаг. Дохионы хэлний орчуулагч болон брайль үсгийн анхан шатны сургалтыг оюутнуудын идэвх санаачилгаар зохион байгуулсан.

МУБИС, хөгжлийн бэрхшээлтэй оюутны сурах эрхийг хангах, орчин бүрдүүлэх чиглэлээр сургалтын журамд өөрчлөлт оруулсан.

Сонсголын бэрхшээлтэй оюутнуудад зориулж МУБИС-ийн сургалтын журам, оюутны журам, элсэлтийн сурталчилгааг дохионы хэлний тайлбартайгаар цахим орчинд байршуулсан.

5.4 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм журмын давуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэх нотолгоо:

Шилжилт, хөдөлгөөн, кредит дүйцүүлэх зохицуулах журамтай, түүнийгээ мөрдөж ажилладаг Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ суралцагчдын эрх ашигт нийцүүлдэг.

МУБИС-ийн Сургалтын журмын “Шилжилт хөдөлгөөнийг зохицуулах” хэсэгт “МУБИС-тай кредит харилцан зөвшөөрөх боломжтой гадаадын их сургууль”, “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэл хийлгэсэн дотоодын их сургууль”-д суралцдаг байх гэсэн заалт нь чанаргүй оюутан шилжин суралцах боломжийг хаасан байна. 2014-2019 оны хичээлийн жилд суралцагчийн шилжилт хөдөлгөөний тайлангаас харахад шилжилт хөдөлгөөн бага байгаа нь мэргэжлээ зорьж сонгосонтой холбоотой байна.

2014-2019 оны хичээлийн жилүүдэд МУБИС-ийн бүрэлдэхүүн сургуулиас шилжин ирсэн 7, бүрэлдэхүүн сургууль руу шилжсэн 3 оюутан байна. Энэ хугацаанд хүндэтгэх шалтгаанаар чөлөө авсан 15 оюутан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/туршлага/

- Оюутнуудтай хийсэн ярилцлагаас дүгнэхэд суралцаж байх хугацаанд нь мэргэжилдээ дур сонирхолтой болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хүлээн зөвшөөрөх хандлагыг сайн төлөвшүүлж байна.

5.5 Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэжил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэх нотолгоо:

МУБИС нь олон улсын стандартыг хангасан төгсөлтийн баримт бичгийг олгодог. 2017-2018 оны хичээлийн жилийн өвлийн улирлын төгсөлтөөс эхлэн дипломын хавсралтад “Төрсөн газар, огноо”, “Элсэлтийн шалгалтын оноо”, “Өмнөх шатны боловсролын үнэлгээний дундаж оноо”-г оруулж өгснөөр оюутан гадаадын их дээд сургуульд элсэн суралцах, дараагийн шатны сургалтад хамрагдах, ажилд ороход дэмжлэг болох, мөн ажил олгогч төгсөгчийн диплом болон хавсралтаас төгсөгчийн үндсэн мэдээлэл, сурлагын амжилт, сургалтаас эзэмших шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагын мэдээллийг авах боломжтой.

Мөн диплом нь үндсэн хавсралтаас гадна нэмэлт хавсралтыг оруулж өгснөөр төгсөгч, эцэг эх, ажил олгогч, дараагийн шатны хөтөлбөрт суралцуулах байгууллага нь МУБИС-ийн тухайн хөтөлбөрийн агуулга, үнэлгээний хэлбэр, хавсралтад бичигдсэн мэдээллийн тайлбар, төгсөлтийн дараах сургалтын мэдээллийг авах боломжтой.

Онцлог зүйл/туршлага/

- Олон улсын стандарт шаардлага хангасан 6 нүүр, 7 агуулга бүхий төгсөлтийн баримт бичиг боловсруулан олгож эхэлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Гадаадын ижил төстэй сургуульд оюутан солилцоогоор сургах боломжийг судлах.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн зорилго, зорилт, түүнд тавигдах шаардлага, хэрэгжүүлэх хүний нөөц, мэргэжлийн зэрэг чадавхийг бүрдүүлж, багшид тавигдах шаардлагын дагуу шинэ багшийн сонгон шалгаруулалтыг зарлаж ил тод, нээлттэй байдлыг хангаж байна.

“Багш, тусгай хэрэгцээт боловсрол” бакалаврын хөтөлбөр нь БоСС-ийн 24 үндсэн болон 8 гэрээт багшийн бүрэлдэхүүнтэй бөгөөд уг хөтөлбөрт ордог 27 багшийн 18 (53-67%) докторын зэрэгтэй (ӨҮТ хуу 113). Нийт багш нарын 77.4% нь үндсэн багш нар байна. Багш, оюутны зохистой тооны харьцаа сүүлийн 5 жилийн дундажаар (2015-2020 он) 1 багшид 2.3 байна.

МУБИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөртэй уг хөтөлбөрийн дагуу багш нарыг хөгжүүлж байна. Шинэ багшийн сонгон шалгаруулалт (зураг 6.1), багшийн гүйцэтгэвэл зохих цагийн ачааллын (зураг 6.2), багш нарын шагнал урамшууллын судалгааг (зураг 6.3) тус бүр гаргасан байна. МУБИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөр /2019-2021/ хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, багш нарын хэрэгцээний судалгаа зэрэг нь сургуулийн үйл ажиллагаа, илрэл нотолгоо зэрэгт тусгагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш, оюутны зохистой тооны харьцаа сүүлийн 5 жилийн дундажаар (2015-2020 он) 1 багшид 2.3 байна.

Анхаарах асуудал:

- Уг хөтөлбөрийг хэрэгжүүлж буй докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь хангалттай хэдий ч тэнхимийн хувьд 3 багштай байгаад анхаарч цаашид дохионы хэлмэрч багштай болох шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр гадаадад дээд боловсрол эзэмшсэн мэргэжлийн багшаар хүний нөөцөө тэлэх, клиник профессороор ажиллуулах шаардлагатай.
- Нарийн мэргэжлийн гэрээт багш нарын ажлын хөлс, үнэлгээг сайжруулж, хөтөлбөрийн чанартай, тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг дэмжих
- Тухайн хөтөлбөрийн чиглэлээр гадаад дотоодын их дээд сургуулиудад амжилттай суралцсан төгсөгчийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 2–3 жил ажиллуулж, дадлагажуулсны дараа багшаар бэлтгэх бодлого боловсруулан ажиллах

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

МУБИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөртэй /2019-2024/ уг хөтөлбөрийн дагуу багш нарыг хөгжүүлж байна. Багш нарыг 3 жил тутамд аттестатчилалд хамруулан тэнцсэн багшийн цалингийн шатлалыг нэмэгдүүлдэг. МУБИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр, БоСС-ийн захирлын ТХББ-ийн хүний нөөцийн төлөвлөлт, МУБИС, Япон улсын Хёго БИС-ийн хоорондын ЭШ, хамтын ажиллагааны зэргийг удирдлага болгон мөрдөн ажиллаж байна.

Багшийн үйл ажиллагаанд Багшид ногдох суралцагчийн тоо болон бие даасан сургалтын ачааллыг жигд байлгах бодлогыг баримтлан багшийн цагийн ногдлын хуваарилалтыг хийдэг гэж тайланд тусгасан байна.

Багшийн ажлын төлөвлөгөөнд сургалт, Э/Ш, арга зүй буюу бүтээлч ажлыг тусгаж улирал бүрээр дүгнүүлдэг байна. Багшийг хөгжүүлэх, гадаадын ижил чиглэлийн сургалт явуулдаг сургуулийн, судлаачдыг урьж хамтарсан семинар зохион байгуулах ажлаа тогтмолжуулах, хамтын ажиллагаатай сургуулиудад очиж туршлага судлах, урт богино хугацаагаар багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан талаарх судалгааг 2013-2019 оноор гаргаж ӨҮТ-д тусгагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаадад суралцуулах гэрээ байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн үр дүн багшлахуйн ур чадвар, сургалтын арга зүйтэй уялдуулах

Зөвлөмж:

- Хийгдсэн төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлж илтгэл, өгүүлэл хэвлүүлэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

МУБИС-ийн хөгжлийн бодлогод эрдэм шинжилгээ, инновацийн талаар тусгасан байна. ТХББ хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх болон тэнхимийн орчин нөхцлийг сайжруулах дэмжлэгийг БСШУСЯ болон БоСС-ийн зүгээс үзүүлдэг.

Багшийн онолын болон заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны чадварыг дээшлүүлэх хэрэгцээг тодорхойлох судалгаа авч шаардлагатай сургалтуудыг явуулдаг. Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нарийн бүтээлийг 1 багшид ноогдох бүтээлээр нь авч үзэхэд гадаад өгүүлэлийн тоо 2-3, төсөл 2-3, эшлэгдсэн бүтээлийн тоо 7, ном 2-3, ӨҮТ-д IF-тай бүтээлийн талаар тусгагдаагүй байна. Эрдэм судлал дэд гарчгийн хүрээнд ЭШ-ний бүтээлийн тоо, өгүүлэл, илтгэл, ТХБ-ийн хөтөлбөр сайжруулахтай холбоотой 6 төсөл, тэнхимийн багш нарийн хэрэгжүүлсэн төсөл 16 зэргийг ӨҮТ-д тусгагдсан байна (Хүснэгт 6.7-11).

БоСС-ийн төсвийн 9% эрдэм шинжилгээний төсөв, эрдэм шинжилгээний төсвийн төлөвлөлт жил тутам нэмэгдэх хандлагатай, нэг тэнхимд ногдох зардал 2.592 сая, нэг багшид ногдох 467.565 төгрөг ноогддог байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимийн 1 багшид ноогдох бүтээлийн тоо 1:2-3 байна.

Анхаарах асуудал:

- Бүтээлийн чөлөө авсан багшийн тоо, тэнхимийн багш нарын бүтээсэн инноваци, ашигтай загвар, патентын судалгааг гаргаагүй.

Зөвлөмж:

- Тэнхимийн багш нарт бүтээлийн чөлөө олгосон тоо
- Үндэсний сурах бичигтэй болох

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

Багш нарыг 3 жил тутамд аттестатчилалд хамруулан тэнцсэн багшийн цалингийн шатлалыг нэмэгдүүлдэг. МУБИС-ийн багшийн ажиллах журмын 5.2 заалтад заасан багшийн ажлыг үнэлж, дүгнэх зарчмын дагуу багш улирал бүр сургалт, эрдэм шинжилгээ, бүтээлч ажлын чиглэлээр өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг хийж байгаа нь үнэлгээний тогтолцоо хэрэгжиж буйг харуулж байна.

Багш нарын талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар ӨҮТ, сургуулийн үйл ажиллагаа, илрэл нотолгоо зэрэгт тусгагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУБИС-ийн багшийн ажиллах журмын 5.2 заалтын дагуу багшийн ажлыг үнэлгээг улирал бүр сургалт, эрдэм шинжилгээ, бүтээлч ажлын чиглэлээр үнэлдэг байна.

Анхаарах асуудал:

- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан, PDCA циклийн дагуу хийсэн эсэх нь тодорхойгүй. Ажлын төлөвлөгөөнд хэрхэн тусгадаг талаар илрэл нотолгоо байсангүй.

Зөвлөмж:

- PDCA циклийн дагуу багшийн үнэлгээг тасралтгүй сайжруулах

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

Чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог 2014 оноос хөгжүүлж, 3 удаагийн шинэчлэл хийсэн байна. ЧДБ-ын тогтолцоо нь үр дүнд суурилсан сургалтын технологийн дагуу, PDCA циклээр хэрэгждэг. ЧДБ-ын үйл ажиллагаад хөтөлбөрийн хороод тэргүүлэх үүрэгтэй оролцдог.

МУБИС-ийн хөгжлийн бодлого, дотоод журам, сургалтын журам, хөтөлбөрийн чанарыг үнэлэх журам, хичээлийн үнэлгээний удирдамж, шалгуур үзүүлэлт зэрэг баримт бичгээр эрх зүйн орчноо бүрдүүлсэн.

Чанарын үнэлгээний төлөвлөгөө, графиктай. БТХБ хөтөлбөрийн чанарыг төгсөгчдийн голч дүнгээр тодорхойлоход 2018-2019 оны төгсөгчдийн голч дүн 3,3, 2019-2020 оны төгсөгчдийн голч дүн 3,2 байгааг тайланд дурдсан.

Оюутны вебэд судлагдахууны болон багшийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг байршуулан тогтмол үнэлгээ хийдэг.

Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр ажил олгогчдын уулзалт, бодлого боловсруулагчдын хэлэлцүүлгийг зохион байгуулж хэвшсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн суралцахуйн болон хичээлийн үр дүнг үнэлэх үнэлгээний даалгаврыг боловсруулж, тохирцыг тэнхимээр хэлэлцүүлдэг.

Анхаарах асуудал:

- Хэрэглэгчийн хүрээний судалгаа, асуумж хангалттай ч өөрийн үнэлгээний асуумж дутагдалтай.

Зөвлөмж:

- Суралцагч, төгсөгчид хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд хүрсэн эсэхээ өөрөө үнэлэх үнэлгээний асуулга, аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

Төгсөгчдийн ажил эрхлэлтийг сүүлийн 5 жилээр хөрвөх 1 жилийн хөтөлбөр болон бакалаврын 4 жилийн хөтөлбөрийн нэгдсэн дүнгийн дундажаар 84,2 хувьтай гэж дүгнэсэн байна. Төгсөгчид ажлын байртай болох хугацаа харьцангуй бага байдаг.

Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаагаар нийт төгсөгчдөөс 5 багш удирдах албан тушаалд, багш ахисан түвшний мэргэжлийн зэрэгт хүрч ажилласан байна.

Төгсөгчдөөс хөтөлбөрийн үр дүнг сайжруулах талаар эргэх холбоотой ажилласны үрээр сургалтын агуулгад тогтмол шинэчлэл хийдэг нь тайлан болон нотлох баримтаас харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Тусгай боловсролын байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах ажлын үнэлэмж, цалин хөлс, тухайн мэргэжилд хандах нийгмийн хандлагын талаар судалгаа хийх шаардлагатай.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

МУБИС нь 3 дах удаа байгууллагаа үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлсэн.

Төгсөгчдийг хөдөө орон нутагт ажиллуулах эрэлт хэрэгцээ өндөр, төгсөгчид нь хүмүүнлэгийн салбарт хөрвөн ажилладаг, сонголын бэрхшээлтэй 16 оюутныг сургаж төгсгөсөн, багш нар нь олон улсын болон төрийн ТББ-уудын захиалгаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, зөвлөхөөр ажилладаг зэрэг нь хөтөлбөрийн үр дүнг нийгэмд хүлээн зөвшөөрч байгаагийн илрэл гэж тайлагнасан.

Хөрвөх хөтөлбөрөөр төгссөн төгсөгчдөөс ОХУ болон бусад их дээд сургуулиудад ахисан түвшинд суралцаж байна.

БТХБ хөтөлбөр нь хэрэгжсэнээс хойш 2 удаагийн төгсөлтийн дараа санаачлагаараа үндэсний хэмжээнд хөтөлбөрөө магадлан итгэмжүүлэхээр өөрийн үнэлгээг хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БТХБ хөтөлбөр нь Монгол Улсад анх удаа хэрэгжиж байгаа, шинэ залуу хөтөлбөр боловч чанар, үр дүнд онцгой анхаарч, үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэх санаачилга гаргасан.

Зөвлөмж:

- Тухайн хөтөлбөрийн хүрээнд зөвлөх баг байгуулж, гадаад дотоодын мэргэжилтэн, профессор багш, ажил олгогч, төгсөгч, хэрэглэгчдийг чанарын хөндлөнгийн үнэлгээнд татан оролцуулах шаардлагатай.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

Өөрийн үнэлгээий тайлан, баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол Улсын Боловсролын Их сургуулийн Боловсрол Судлалын сургуулийн “Багш, тусгай хэрэгцээт боловсрол” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Боловсролын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /х/х, хангаагүй дэд шалгуур байвал үндэслэлийг тодорхой бичнэ./
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	+			
2	Сургалтын үйл ажиллагаа	+			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	+			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	+			
6	Багшийн үйл ажиллагаа	+			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	+			
Дүгнэлт		БҮРЭН ХАНГАСАН			

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Б.Одончимэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....О.Болорсайхан

.....Б.Гэрэлтуяа

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> Тухайн хөтөлбөрийн төгсөгчийн загварт суурилсан боловсролын зорилгыг /PEO/ нарийвчлан боловсруулж, хөтөлбөрийн үр дүнг SMART зарчимд нийцүүлэх;
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Тусгай сурганы дидактик арга зүйн агуулгыг гүнзгийрүүлэн хэрэгжүүлэх; цаашид хөтөлбөртөө шинээр боловсруулж буй мэргэшлийн үндэсний хүрээ, үндэсний хэв шинжийг тусган хөгжүүлэх;
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> Номын сангийн фондод хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулан сурах бичгийг брайль, дейзи хэлбэрээр нэмэгдүүлэх, зарим хичээлийн агуулгыг дохиожуулах;
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> Тэгш хамруулан сургах үзэл санааг түгээн дэлгэрүүлсэн дидактик-сэтгэл зүйн мэргэжлийн сэтгүүл эрхлэн гаргах; тухайн хөтөлбөрийн нэг оюутанд ноогдох зардлыг хөтөлбөрийн онцлогт нийцүүлэн нарийвчлан төсөвлөх; холбогдох веб сайтад БТХБ хөтөлбөрийн мэдээллийг идэвхтэй байршуулах;
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Тус хөтөлбөрт элсэгчдэд харилцаа, хандлага, сэтгэл зүйн төлөвшлийн талаар тодорхой шалгуур тавих; гадаадын ижил хөтөлбөр хэрэгжүүлэгч сургуулиудтай цахим эх сурвалж солилцох, оюутан солилцох, дадлага зохион байгуулах ажлыг санаачлах;
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Нарийн мэргэжлийн багш нараар хүний нөөцөө бүрдүүлэх; гэрээт багш нарын ажлын хөлс, үнэлгээг сайжруулах; клиник профессороор ажиллуулах; хөтөлбөрийн чиглэлээр гадаад дотоодод амжилттай төгссөн төгсөгчийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 2–3 жил ажиллуулан дадлагажуулсны дараа багшаар бэлтгэх бодлого баримтлах; PDSA циклийн дагуу багшийн үнэлгээг тасралтгүй сайжруулах;
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> Суралцагч, төгсөгчид хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд хүрсэн эсэхээ өөрөө үнэлэх үнэлгээний асуулга, аргачлал боловсруулан үр дүнг тооцох; хөтөлбөрийн дэд хороог гадаад дотоодын эрдэмтэн, мэргэжилтэн, профессор багш, ажил олгогч, төгсөгч, хэрэглэгчдээр өргөтгөж, чанарын хөндлөнгийн үнэлгээнд татан оролцуулах;

IV. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу, Утас: 7012 0013, <http://www.msue.edu.mn>

2020.06.08 № 1/50
танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

Шинжээчийн тайлантай танилцсан
тухай

Багш, тусгай хэрэгцээт боловсрол /D011406/ хөтөлбөрт хийсэн шинжээчийн үнэлгээний тайлантай уншиж танилцаад үнэлгээ, зөвлөмжтэй санал бүрэн нийцэж байна.

Цаашид өгсөн заавар, зөвлөмжийн дагуу "Багш, тусгай хэрэгцээт боловсрол"-ын хөтөлбөрийг тасралтгүй засаж, сайжруулах төлөвлөгөө гарган, тайланд тусгагдсан зөвлөмж, анхаарах зүйлс, дүгнэлтийн дагуу хөтөлбөрийн тасралтгүй хөгжлийг ханган ажиллах болно.

ЗАХИРАЛ, ДЭД ПРОФЕССОР Г.ЦОГЗОЛМАА



202009100